

ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Орхон аймгийн Татварын хэлтсийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ОРА-2024/25/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Эрдэнэт хот 2024 он</p>	<p>Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Ц.Нармандах Утас: 70353088 Цахим хаяг: narmandakhts@audit.gov.mn</p> <p>Аудитын менежер: Б.Буян-Ундрах Утас: 70355805 Цахим хаяг: buyanundrakhb@audit.gov.mn</p> <p>Аудитор: Б.Бямбатогтох Утас: 70357955 Цахим хаяг: byambatogtokhb@audit.gov.mn</p>
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Нэг. Хараат бус аудиторын дүгнэлт



ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

61033 Орхон аймаг, Баян-Өндөр сум,
Урт булаг баг, Ханддоржийн
гудамж, Утас/Факс: 70359826
Цахим шуудан: orkhon@audit.gov.mn

2024.08.22 № 19

танай _____-ны № _____-т

ОРХОН АЙМГИЙН ТАТВАРЫН
ХЭЛТСИЙН ДАРГА
Б.ЦЭВЭЭНСҮРЭН ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Орхон аймгийн Татварын хэлтсийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Орхон аймгийн Татварын хэлтсийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Орхон аймгийн Татварын хэлтсийн 2023 оны үйл ажиллагааны зарцуулах баталсан төсөв, төвлөрүүлэх орлогыг бүрэн төвлөрүүлж, төсвийг 8.3 хувиар хэмнэж, төсвийн гүйцэтгэл 91.7 хувьтай тайлагнаж, авлага, өр төлбөр үүсгэхгүй ажилласан байна.

Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл өмнөх оны үлдэгдлээс 8,590.5 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хэмнэлтээс ахмадын сангийн дансанд төвлөрүүлсэнтэй холбоотой байна.

Аудитын гол асуудал

Сангийн сайдын 2023 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн 33 дугаар тушаалаар баталсан "Татварын улсын байцаагчид үр дүнгийн шагнал олгох журам"-г үндэслэн Татварын Ерөнхий газраас ирүүлсэн үнэлгээг үндэслэн, байгууллагын даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн татварын улсын байцаагч нарт нийт 179,055.4 мянган төгрөгийн үр дүнгийн шагнал олгосон байна.

D:\my doc\lalban bichig\2024-A4.doc

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 07 дугаар сарын 08-ны өдрийн 11/04 дүгээр тогтоолыг үндэслэн, байгууллагын даргын тушаалаар орон нутагт ажилласны нэмэгдлийг албан хаагч тус бүр 40 хувиар тооцож, нийт 111,876.7 мянган төгрөгийн нэмэгдэл олгосон байна.

Мөн Засгийн газрын 2023 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн хуралдааны 52 дугаар тэмдэглэл, Татварын ерөнхий газрын даргын 2023 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн А/225 дугаар тушаалыг үндэслэн байгууллагын даргын тушаалаар цалингийн сангийн хэмнэлтээс албан хаагчдад нийт 49,952.8 мянган төгрөгийн мөнгөн урамшуулал олгожээ.

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг 5 зорилт, 38 арга хэмжээг хэрэгжүүлэхээр аймгийн Засаг даргатай байгуулж, хэрэгжилтийг 98.6 хувьтай үнэлсэн байна.

Тухай аудитыг хийх явцад аудитын дүгнэлт, тайлантай холбогдуулан аудит гүйцэтгэж буй төрийн аудитын албан хаагчид аливаа этгээдийн нөлөөлөл, мэдээллийн нууцлал, ёс зүйтэй холбоотой холбогдох хуулийн дагуу мэдэгдлүүдийг гарган баталгаажуулсан болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРМАНДАХ

Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	44,126,275.22	59,490,441.30
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	7,489,405.00	16,079,905.00
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	7,489,405.00	16,079,905.00
3121	Төгрөг	7,489,405.00	16,079,905.00
31211	Төрийн сангийн харилцах	7,489,405.00	16,079,905.00
35	БАРАА МАТЕРИАЛ	36,636,870.22	43,410,536.30
354	Хангамжийн материал	36,636,870.22	43,410,536.30
35410	Бичиг хэргийн материал	6,395,900.00	5,710,003.60
35420	Аж ахуйн материал	28,606,967.22	34,441,951.22
35430	Сэлбэг хэрэгсэл	988,000.00	1,740,000.00
35440	Түлш, шатах тослох материал	467,023.00	1,326,181.48
35470	Бусад хангамжийн материал	178,980.00	192,400.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	934,738,160.32	857,076,034.43
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	934,738,160.32	756,836,034.43
392	Биет хөрөнгө	834,498,160.32	755,992,134.43
39201	Барилга, байгууламж, орон сууц	522,136,065.00	522,136,065.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-48,718,178.61	-71,275,072.76
39203	Авто-тээврийн хэрэгсэл	161,800,000.00	161,800,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-46,206,080.40	-62,375,989.20
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	301,416,854.87	317,013,669.87
39206	Хуримтлагдсан элэгдэл	-109,496,267.97	-156,616,356.90
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	128,513,600.00	97,066,400.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-74,947,832.57	-50,912,681.58
393	Биет бус хөрөнгө	100,240,000.00	100,240,000.00
39301	Програм хангамж	1,430,000.00	1,430,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-1,430,000.00	-1,430,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	100,240,000.00	100,240,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	978,864,435.54	916,566,475.73
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	0.00	0.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	978,864,435.54	916,566,475.73
51	Засгийн газрын хувь оролцоо	978,864,435.54	916,566,475.73

511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	720,858,474.98	720,858,474.98
51101	Өмч: - төрийн	720,858,474.98	720,858,474.98
512	Хуримтлагдсан үр дүн	242,617,090.56	180,319,130.75
51210	Өмнөх үеийн үр дүн	53,098,161.64	242,617,090.56
51220	Тайлант үеийн үр дүн	189,518,928.92	-62,297,959.81
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	15,388,870.00	15,388,870.00
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	978,864,435.54	916,566,475.73

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,423,398,356.84	2,021,863,527.08
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	286,937,356.84	52,709,127.08
120	Нийтлэг татварын бус орлого	286,937,356.84	52,709,127.08
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	286,937,356.84	37,709,127.08
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	286,937,356.84	37,709,127.08
120009	Бусад орлого	0.00	15,000,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,136,461,000.00	1,969,154,400.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	961,382,400.00	1,630,244,200.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	961,382,400.00	1,630,244,200.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	175,078,600.00	338,910,200.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	175,078,600.00	338,910,200.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,226,283,514.34	2,084,161,486.89
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,226,283,514.34	2,084,161,486.89
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,077,759,858.09	1,872,552,182.57
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	652,837,668.00	1,281,311,215.00
210101	Үндсэн цалин	437,654,644.00	616,375,850.00
210102	Нэмэгдэл цалин	83,395,704.00	344,376,416.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	66,942,000.00	64,230,293.00
210104	Урамшуулал	64,845,320.00	256,328,656.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	83,757,420.00	160,027,669.85
210201	Тэтгэврийн даатгал	58,341,049.36	114,309,616.56
210202	Тэтгэмжийн даатгал	6,850,623.74	12,130,725.76

210203	ҮОМШ өвчний даатгал	5,174,485.69	9,279,486.17
210204	Ажилгүйдлын даатгал	1,217,387.74	2,210,346.65
210205	Эрүүл мэндийн даатгал	12,173,873.47	22,097,494.71
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	17,462,176.92	18,034,978.64
210301	Гэрэл цахилгаан	5,435,840.12	7,614,024.12
210302	Түлш, халаалт	7,388,614.80	8,256,549.52
210303	Цэвэр, бохир ус	4,637,722.00	2,164,405.00
2104	Хангамж, бараа материалын зардал	64,033,628.40	102,635,061.38
210401	Бичиг хэрэг	18,223,875.80	65,335,886.00
210402	Тээвэр шатахуун	11,963,703.08	9,426,688.00
210403	Шуудан холбоо, интернэтийн төлбөр	6,023,480.83	6,790,951.38
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	645,000.00	536,400.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	22,509,468.64	12,584,200.00
210408	Бараа материал акалсны зардал	4,668,100.05	7,960,936.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,589,930.00	26,293,750.00
210604	Урсгал засвар	2,589,930.00	26,293,750.00
2107	Томилолт, зочны зардал	1,878,200.00	1,454,000.00
210702	Дотоод албан томилолт	1,878,200.00	1,454,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	159,817,306.00	170,187,566.81
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	157,151,593.00	168,193,255.81
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	864,000.00	0.00
210803	Даатгалын үйлчилгээ	106,920.00	106,920.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	268,573.00	226,251.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	44,000.00	44,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	595,000.00	855,000.00
210807	Газрын төлбөр	751,800.00	751,800.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	35,420.00	10,340.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	95,383,528.77	112,607,940.89
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	733,900.00	40,000.00
210902	Хичээл үйлвэрлэлийн дадлага хийх	24,038,000.00	7,500,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл хорогдлын зардал	70,611,628.77	105,067,940.89
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	148,523,656.25	211,609,304.32
2132	Бусад урсгал шилжүүлэг	41,898,648.00	47,599,803.00

213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	30,468,648.00	34,976,803.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	11,430,000.00	12,623,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	106,625,008.25	164,009,501.32
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	106,625,008.25	164,009,501.32
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	197,114,842.50	-62,297,959.81
145	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	0.00	0.00
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	7,595,913.58	0.00
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	7,595,913.58	0.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-7,595,913.58	0.00
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	189,518,928.92	-62,297,959.81

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	1,136,461,000.00	1,984,154,400.00
11	ТАТВАРЫН ОРЛОГО	0.00	0.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	0.00	15,000,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	0.00	15,000,000.00
120009	Бусад орлого	0.00	15,000,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,136,461,000.00	1,969,154,400.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	961,382,400.00	1,630,244,200.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	961,382,400.00	1,630,244,200.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	175,078,600.00	338,910,200.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	175,078,600.00	338,910,200.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,143,415,250.00	1,975,563,900.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,143,415,250.00	1,975,563,900.00
210	БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	994,891,593.75	1,762,768,095.68
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	652,837,668.00	1,281,311,215.00
210101	Үндсэн цалин	437,654,644.00	616,375,850.00
210102	Нэмэгдэл	83,395,704.00	344,376,416.00
210103	Унаа хоолны Хөнгөлөлт	66,942,000.00	64,230,293.00
210104	Урамшуулал	64,845,320.00	256,328,656.00

2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	83,757,420.00	160,027,669.85
210201	Тэтгэврийн даатгал	58,341,049.36	114,309,616.56
210202	Тэтгэмжийн даатгал	6,850,623.74	12,130,725.76
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,174,485.69	9,279,486.17
210204	Ажилгүйдлийн даатгал	1,217,387.74	2,210,346.65
210205	Эрүүл мэндийн даатгал	12,173,873.47	22,097,494.71
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	17,755,176.92	18,743,182.43
210301	Гэрэл, цахилгаан	5,435,840.12	8,322,227.91
210302	Түлш, халаалт	7,681,614.80	8,256,549.52
210303	Цэвэр, бохир ус	4,637,722.00	2,164,405.00
2104	Хангамж, бараа материалын зардал	34,541,342.83	35,849,716.40
210401	Бичиг хэрэг	9,876,800.00	14,539,820.00
210402	Тээвэр, шатахуун	10,355,800.00	10,100,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	6,068,480.83	5,673,902.40
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	645,000.00	536,400.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	7,595,262.00	4,999,594.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	7,382,600.00	32,111,200.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,300,000.00	0.00
210604	Урсгал засвар	6,082,600.00	32,111,200.00
2107	Томилолт, зочны зардал	1,878,200.00	1,454,000.00
210702	Дотоод албан томилолт	1,878,200.00	1,454,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	163,979,386.00	208,143,672.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	161,249,093.00	206,159,701.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	864,000.00	0.00
210803	Даатгалын үйлчилгээ	106,920.00	106,920.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	268,573.00	226,251.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	44,000.00	44,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	695,000.00	855,000.00
210807	Газрын төлбөр	751,800.00	751,800.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	32,759,800.00	25,127,440.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,762,900.00	2,578,900.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	30,996,900.00	22,548,540.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	148,523,656.25	212,795,804.32

2132	Бусад урсгал шилжүүлэг	41,898,648.00	48,786,303.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	30,468,648.00	34,976,803.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	11,430,000.00	13,809,500.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	106,625,008.25	164,009,501.32
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	106,625,008.25	164,009,501.32
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	-6,954,250.00	8,590,500.00
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
4	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (4)	0.00	0.00
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	0.00	0.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-6,954,250.00	8,590,500.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	14,443,655.00	7,489,405.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	7,489,405.00	16,079,905.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2021 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	720,858,474.98	15,388,870.00	53,098,161.64	789,345,506.62
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	720,858,474.98	15,388,870.00	53,098,161.64	789,345,506.62
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	0.00	0.00	0.00	0.00
C05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	0.00	0.00	0.00	0.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00
C07	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	189,518,928.92	189,518,928.92
C08	2022 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	1,441,716,949.96	30,777,740.00	485,234,181.12	1,957,728,871.08
D01	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	1,441,716,949.96	30,777,740.00	485,234,181.12	1,957,728,871.08
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00

D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,441,716,949.96	30,777,740.00	485,234,181.12	1,957,728,871.08
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	0.00	0.00	0.00	0.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	0.00	0.00	0.00	0.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	0.00	0.00	0.00	0.00
D08	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	-62,297,959.81	-62,297,959.81
D09	2023 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	720,858,474.98	15,388,870.00	180,319,130.75	916,566,475.73

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,630,244,200.00	1,494,275,504.43
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,630,244,200.00	1,494,275,504.43
210	БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,590,867,300.00	1,448,489,201.43
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	1,302,758,400.00	1,181,746,206.00
210101	Үндсэн цалин	594,604,700.00	599,150,737.00
210102	Нэмэгдэл цалин	303,279,500.00	262,036,520.00
210103	Унаа хоолны Хөнгөлөлт	76,183,800.00	64,230,293.00
210104	Урамшуулал	328,690,400.00	256,328,656.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	162,844,800.00	147,715,943.85
210201	Тэтгэврийн даатгал	110,734,500.00	101,997,890.56
210202	Тэтгэмжийн даатгал	13,027,600.00	12,130,725.76
210203	ҮОМШӨ-ний даатгал	10,422,000.00	9,279,486.17
210204	Ажилгүйдлийн даатгал	2,605,500.00	2,210,346.65
210205	Эрүүл мэндийн даатгал	26,055,200.00	22,097,494.71
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	23,953,100.00	18,743,182.43
210301	Гэрэл, цахилгаан	8,653,100.00	8,322,227.91
210302	Түлш, халаалт	11,442,500.00	8,256,549.52
210303	Цэвэр, бохир ус	3,857,500.00	2,164,405.00
2104	Хангамж, бараа материалын зардал	19,176,400.00	19,168,498.15
210401	Бичиг хэрэг	4,040,000.00	4,039,960.00
210402	Тээвэр, шатахуун	4,200,000.00	4,200,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	5,400,000.00	5,392,544.15
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	536,400.00	536,400.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,000,000.00	4,999,594.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	17,500,000.00	17,489,700.00

210604	Урсгал засвар	17,500,000.00	17,489,700.00
2107	Томилолт, зочны зардал	1,454,000.00	1,454,000.00
210702	Дотоод албан томилолт	1,454,000.00	1,454,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	56,125,600.00	55,131,671.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	54,954,200.00	54,002,700.00
210803	Даатгалын үйлчилгээ	107,000.00	106,920.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	268,600.00	226,251.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	44,000.00	44,000.00
210807	Газрын төлбөр	751,800.00	751,800.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	7,055,000.00	7,040,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	55,000.00	40,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага	7,000,000.00	7,000,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	39,376,900.00	45,786,303.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	39,376,900.00	45,786,303.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	34,976,900.00	34,976,803.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	4,400,000.00	10,809,500.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,630,244,200.00	1,502,866,004.43
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,630,244,200.00	1,487,866,004.43
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,630,244,200.00	1,487,866,004.43
122	ТУСЛАМЖИЙН ЭХ ҮҮСВЭРЭЭС САНХҮҮЖИХ	0.00	0.00
14	БУСАД ЭХ ҮҮСВЭР	0.00	15,000,000.00
140020	Бусад орлого	0.00	15,000,000.00
88	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	16,079,905.00
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	1	1
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1
610001	Төсвийн байгууллага	1	1
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	47	46
620001	Удирдах ажилтан	1	1
620002	Гүйцэтгэх ажилтан	39	38
620003	Үйлчлэх ажилтан	7	7

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	0.00
I	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	0.00	338,910,200.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	0.00	338,910,200.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	0.00	314,278,894.25
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	0.00	99,565,009.00
210101	Үндсэн цалин	0.00	17,225,113.00
210102	Нэмэгдэл	0.00	82,339,896.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	0.00	12,311,726.00

210201	Тэтгэврийн даатгал	0.00	12,311,726.00
2104	Хангамж, бараа материалын зардал	0.00	16,681,218.25
210401	Бичиг хэрэг	0.00	10,499,860.00
210402	Тээвэр, шатахуун	0.00	5,900,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	0.00	281,358.25
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	0.00	14,621,500.00
210604	Урсгал засвар	0.00	14,621,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	0.00	153,012,001.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	0.00	152,157,001.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	0.00	855,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	0.00	18,087,440.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	0.00	2,538,900.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	0.00	15,548,540.00
212	ТАТААС	0.00	21,631,305.75
2121	Төрийн өмчит байгууллагад олгох татаас	0.00	21,631,305.75
212101	Төрийн өмчит байгууллагад олгох татаас	0.00	21,631,305.75
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	0.00	3,000,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	0.00	3,000,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	0.00	3,000,000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	0.00	338,910,200.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	0.00	338,910,200.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	0.00	338,910,200.00
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	0.00	0.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	0.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	0.00

Гурав. Аудитын илрүүлэлт:

Аудитаар нийт 13,972.2 мянган төгрөгийн алдаа¹ илэрснээс аудитын явцад 13,972.2 мянган төгрөгийн 5 алдааг залруулж тайлагналаа.

Залруулсан алдаа:

- Албан хаагчдад орон нутгийн нэмэгдлийг 4,471.6 мянган төгрөгөөр илүү тооцоолж олгосон нь УСНББОУС 1, 2 болон үнэн зөв байх батламж мэдэгдлийг хангаагүй тул албан хаагчдаас суутган тооцож, төсөвт татан төвлөрүүлсэн,
- Хагас жилийн санхүүгийн тайланд шатахууны урамшуулал, орлогыг 263.8 мянган төгрөгөөр дутуу бүртгэж тайлагнасан нь УСНББОУС 1, 12 болон аудитын иж бүрэн байх, үнэлгээ ба хуваарилалт, үнэн зөв байх, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангаагүй тул бараа материалын тайланд,
- Данснаас хассан 7,960.9 мянган төгрөгийн аж ахуйн материалыг худалдан зарцуулснаар тайлагнасан нь УСНББОУС 1, 12 болон аудитын тохиолдсон байх, иж

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

бүрэн байх, үнэлгээ ба хуваарилалт, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангаагүй тул бараа материалын тайланд,

- Төсвийн гүйцэтгэлийн тайлан зөрүүтэй тайлагнасан нь УСНББОУС 1, 2 болон иж бүрэн байх, үнэлгээ ба хуваарилалт, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангаагүй тул төсвийн гүйцэтгэлийн тайланд,
- Бараа материалын аж ахуйн материалын тайланд 843.9 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийн шинжтэй хөрөнгө, 432.0 мянган төгрөгийн сэлбэг хэрэгслийг бүртгэж тайлагнасан нь УСНББОУС 1, 12, 17 болон аудитын иж бүрэн байх, үнэлгээ ба хуваарилалт, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангаагүй тул бараа материал, үндсэн хөрөнгийн тайланд тус тус залруулав.

Аудитаар нийт 13,286.6 мянган төгрөгийн зөрчил² илэрснээс, 506.7 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоож, зөрчил арилгах 1 албан шаардлага хүргүүлж, 12,779.9 мянган төгрөгийн 5 зөвлөмж өгсөн.

5.1 Төлбөрийн акт

Татварын улсын байцаагчид 506.7 мянган төгрөгийн цалин илүү тооцоолж олгосон тул 1 төлбөрийн акт тогтоов.

5.2 Албан шаардлага

Жолоочийн тооцооны хуудас хөтлөөгүй, бараа материалын орлого, зарлагыг бүртгэж тайлагнаагүй, анхан шатны баримт цэгцлээгүй, нэр төрлөөр ангилж бүртгээгүй зөрчилд албан шаардлага хүргүүлэв.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Ахмадын сангийн данстай холбоотой асуудал

Илрүүлэлт: Байгууллагын төсөвт тусгаагүй, төсвийн хэмнэлтээс ахмадын санд 12,779.9 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна. Энэ нь Засгийн газрын 2017 оны 197 дугаар тогтоолоор баталсан "Ахмадын сан байгуулан ажиллуулах журам"-н 1.3-д "Төсөвт байгууллагын тухайд цалингийн сангийн гурав хүртэлх хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгөөр сан байгуулж, шаардагдах хөрөнгийг төсөвтөө жил бүр тусгана" гэж заасантай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Ахмадын сангийн төсвийг тухайн жилийн төсөвтөө тусган, төлөвлөж байх.

2. Бараа материалын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт: Худалдан авч орлогоор бүртгэсэн бараа, ажил үйлчилгээний тоо хэмжээ, үнийн дүнг цахим төлбөрийн баримтад нийт дүнгээр бүртгэсэн байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.6-д "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна", Сангийн сайдын 2017 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн 347 дугаар тушаалаар баталсан "Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягыг нөхөх заавар"-ын 6 дах хэсэг 5-д "Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм. Төлбөрийн баримтад борлуулагч, худалдан авагчийг таних тэмдэг, татвар төлөгчийн дугаар, төлбөр тооцоо хийгдсэн он, сар, өдөр, бараа, ажил, үйлчилгээний нэр, код, тоо хэмжээ, үнэ, татварын дүнг тусгана. Төлбөрийн баримтыг цахим гарын үсэг эсхүл тусгай нууцлалын QR кодоор баталгаажуулах бөгөөд Монгол Улсын Стандарт MNS 6529:2015 "Татварын нэгдсэн системд ашиглах

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

төлбөрийн баримтын ерөнхий шаардлага"-д заасан загварын дагуу бүртгэлийн машинаар хоёр хувь үйлдэнэ" гэж заасантай нийцэхгүй, аудитын ангилал, толилуулга, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Бараа, ажил, үйлчилгээний анхан шатны баримтыг холбогдох хууль, журамд нийцүүлж, бүртгэж тайлагнах.

3. Тодруулга тайлантай холбоотой асуудал

Илрүүлэлт: Тайлант онд санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 11 дүгээр сарын 27-ны өдрийн 388 дугаар тушаалын дагуу санхүүгийн тайлангийн тодруулгыг зохих журмын дагуу бэлтгэж тайлагнаагүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8.1-д "Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлангаа гаргах үүрэг бүхий аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн тайлан нь дараах бүрэлдэхүүнтэй байна", 8.1.5-д "санхүүгийн тайлангийн тодруулга" гэж заасантай нийцэхгүй, аудитын иж бүрэн байх, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Санхүүгийн тайланг иж бүрэн, үнэн зөв бэлтгэж байх.

4. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Төсөв, хөрөнгө зарцуулах, үндсэн хөрөнгө орлогод авах, хөрөнгө данснаас хасахтай холбоотой 41,932.4 мянган төгрөгийн 7 тушаал шийдвэрийг шилэн дансны цахим хуудсанд мэдээлээгүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.6-д "дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх"; 16.5.7-д "байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, үр дүнгийн гэрээний биелэлтийг үнэн зөв гаргах, тогтоосон хугацаанд тайлагнах", Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4-д "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ", 6.4.8-д "бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, ер, авлага үүсгэсэн аливаа шийдвэр" гэж заасантай нийцэхгүй, аудитын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Шилэн дансны цахим хуудсанд мэдээллийг бүрэн байршуулж байх.

5. Тодруулга тайлантай холбоотой асуудал

Илрүүлэлт: Цалин хөлсийг нийгмийн даатгалын шимтгэлийн тайланд зөрүүтэй тайлагнасан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5.1-д "Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн дараах зарчмыг баримтална", 5.1.4-д "үнэн зөв байх", 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно" гэж заасантай нийцэхгүй, аудитын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Тайлан мэдээг үнэн зөв тайлагнаж байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2024 оны 07 дугаар сарын 05-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Дөрөв. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл:

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Байгууллагын нэр	Нийт алдаа	Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан	Буруу тусган илэрхийлсэн	/мянган төгрөг/		Зөвлөмж
				Үүнээс Залруулсан	Залруулаагүй	

	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Татварын хэлтэс	5	13,972.2	1	263.8	4	13,708.4	5	13,972.2				
Дүн	5	13,972.2	1	263.8	4	13,708.4	5	13,972.2				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөг/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Татварын хэлтэс	6	13,286.6	1	506.7	1	-	4	12,779.9				
Дүн	6	13,286.6	1	506.7	1	-	4	12,779.9				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөг/

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс						
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил									
Татварын хэлтэс	1	-						1	-
Дүн	1	-						1	-

Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр				
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Өөрчлөлтгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан	
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй					
A	1	2	3	4	5	7	8	9	10	
1	ТШЗ	1	1			1				
	НИЙТ	1	1			1				